

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/131/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.khuvsgul.audit.mn](http://www.khuvsgul.audit.mn)  
Мөрөн хот  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: : 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг  
Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)  
Ихэрмөрөн-аудит ХХК-ийн  
Захирал: Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)  
Аудитор Д.Оюундаваа  
Утас 99389692 Цахим хаяг: [Оyуnаа\\_60@yahoo.com](mailto:Оyуnаа_60@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна.

## Агуулга

1 Аудитын санал дүгнэлт .....	1
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт .....	15
Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй болно.....	15
Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчидийн хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.24 № 01/137  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
М.СОНОМВАНЧИГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>299,958,550.53</u>	<u>310,345,009.91</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	299,958,550.53	310,345,009.91
351	Түүхий эд материал	8,643,170.00	10,962,620.00
35130	Эм боох материал	8,643,170.00	10,962,620.00
354	Хангамжийн материал	283,760,380.53	288,897,389.91
35410	Бичиг хэргийн материал	4,231,739.65	6,710,848.28
35420	Аж ахуйн материал	43,739,904.00	9,317,279.00
35440	Түлш, шатах тослох материал	8,920,500.00	12,535,000.00
35450	Барилгын засварын материал	4,143,200.00	5,722,100.00
35460	Хүнсний материал	19,555,214.38	40,141,282.10
35470	Бусад хангамжийн материал	203,169,822.50	214,470,880.53
35500	Сав баглаа боодол	160,000.00	160,000.00
35600	Мал амьтад	7,395,000.00	10,325,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,213,609,142.32</u>	<u>7,045,547,938.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,213,609,142.32	7,045,547,938.03
392	Биет хөрөнгө	7,122,290,017.24	6,955,212,396.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,218,505,828.00	7,198,506,828.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-338,818,855.68	-582,861,618.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-312,500.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	332,517,299.31	228,288,218.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-260,669,278.43	-57,860,152.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	221,801,394.08	226,160,665.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-124,143,293.14	-104,291,744.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,874,410.00	3,815,356.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,624,409.80	-1,499,999.76
39217	Ном	71,846,922.90	40,267,343.78
393	Биет бус хөрөнгө	91,319,125.08	90,335,541.72
39301	Програм хангамж	8,462,000.00	8,360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,428,874.92	-2,310,458.28
39303	Бусад биет бус хөрөнгө	84,286,000.00	84,286,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,513,567,692.85</u>	<u>7,355,892,947.94</u>
413	Өглөг	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,513,567,692.85</u>	<u>7,355,892,947.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,513,567,692.85	7,355,892,947.94

**Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	785,619,581.97	785,619,581.97
51101	Өмч: - төрийн	785,619,581.97	785,619,581.97
512	Хуримтлагдсан үр дүн	5,345,819,557.88	5,192,261,451.11
51210	Өмнөх үеийн үр дүн	5,345,819,557.88	5,330,337,296.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-137,675,744.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,382,128,553.00	1,377,611,814.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,513,567,692.85</u>	<u>7,355,892,947.94</u>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,030,664,275.41	2,189,970,786.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,583,467,975.41	1,695,778,483.53
120	Нийтлэг татварын бус орлого	5,906,779,375.41	168,683,483.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,906,779,375.41	168,683,483.53
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,093,300.00	00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	3320,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,900,886,075.41	165,363,483.53
131007	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,676,688,600.00	1,527,095,000.00
132001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,676,688,600.00	1,527,095,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,196,300.00	494,192,302.63
132	Орон нутгийн төсвөөс	446,146,300.00	474,276,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	446,146,300.00	474,276,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,050,000.00	19,915,702.63
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,861,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	12,237,102.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,817,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,246,063,336.11	2,290,283,410.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,246,063,336.11	2,290,283,410.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,092,413,469.11	2,207,824,512.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,161,417,579.00	1,139,210,643.83
210101	Үндсэн цалин	951,163,554.54	827,994,284.41
210102	Нэмэгдэл	97,280,300.00	239,238,194.09
210104	Урамшуулал	112,973,724.46	71,978,165.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,430,247.00	151,867,418.91
210201	Тэтгэврийн даатгал	91,530,012.18	106,411,096.18
210202	Тэтгэмжийн даатгал	13,763,660.41	11,688,757.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,039,634.58	9,213,246.11

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,652,572.43	2,229,829.51
210205	Эрүүл мэндийн даатгал	28,444,367.40	22,324,489.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	431,047,003.00	461,953,368.00
210301	Гэрэл, цахилгаан	5,242,271.00	5,291,436.50
210302	Түлш, халаалт	424,804,732.00	456,023,931.50
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	638,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,301,915.00	48,362,257.49
210401	Бичиг хэрэг	1,916,894.00	1,534,475.00
210402	Тээвэр, шатахуун	6,499,830.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,310.00	1,055,816.00
210404	Ном, хэвлэл	5,093,300.00	3,817,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	6,452,590.00	4,015,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,997,050.00	9,538,003.00
210408	Бараа материал акталсны зардал	5,327,941.00	24,901,463.49
2105	Нормативт зардал	62,184,400.80	95,336,789.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	979,850.00	9,067,250.00
210502	Хоол, хүнс	59,470,850.80	80,984,039.04
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,733,700.00	5,285,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,124,000.00	6,740,511.00
210604	Урсгал засвар	9,124,000.00	6,740,511.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	548,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	548,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,525,000.00	6,762,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,025,000.00	5,754,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243,383,324.31	297,043,024.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,210,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,727,100.00	4,546,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	236,656,224.31	291,286,124.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,649,867.00	82,458,898.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,239,800.00	48,364,266.81
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,810,800.00	48,364,266.81
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,429,000.00	00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	858,297.00	159,332.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	858,297.00	159,332.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	121,551,770.00	33,935,299.45
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	121,551,770.00	33,935,299.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,784,600,939.30	-100,312,624.59
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	55,999.62	37,363,120.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	55,999.62	37,363,120.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-55,999.62	-37,363,120.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,784,544,939.68	-137,675,744.91

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	/ төгрөгөөр /			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
20..оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	785,619,581.97	1,384,531,635.33	-440,946,095.28	1,729,205,122.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,403,082.33	2,403,082.33
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	785,619,581.97	1,384,531,635.33	-438,543,012.95	1,731,608,204.36
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,784,544,939.68	5,784,544,939.68
2020оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	785,619,581.97	1,382,128,553.00	5,345,819,557.88	7,513,567,692.85
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	785,619,581.97	1,382,128,553.00	5,345,819,557.88	7,513,567,692.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-15,482,261.82	15,482,261.82
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	785,619,581.97	1,382,128,553.00	5,330,337,296.06	7,498,085,431.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-4,516,738.18	00.00	-4,516,738.18
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-137,675,744.91	-137,675,744.91
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	785,619,581.97	1,377,611,814.82	5,192,661,551.15	7,355,892,947.94

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,128,978,200.00</u>	<u>2,021,287,302.63</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,681,781,900.00	1,527,095,000.00

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,093,300.00	00
	Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих	5,093,300.00	00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,676,688,600.00	1,527,095,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,676,688,600.00	1,527,095,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,196,300.00	494,192,302.63
1320	Орон нутгийн төсвөөс	446,146,300.00	474,276,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	446,146,300.00	474,276,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,050,000.00	19,915,702.63
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,861,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	12,237,102.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,817,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,089,715,450.00	1,999,741,302.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,089,715,450.00	1,999,741,302.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,936,065,583.00	1,902,943,936.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,161,235,472.07	1,139,210,643.83
210101	Үндсэн цалин	950,981,447.61	827,994,275.29
210102	Нэмэгдэл	97,280,300.00	239,238,203.21
210104	Урамшуулал	112,973,724.46	71,978,165.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,430,250.93	151,867,418.91
210201	Тэтгэврийн даатгал	91,530,016.11	106,786,067.41
210202	Тэтгэмжийн даатгал	13,763,660.41	11,385,788.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,039,634.58	9,088,308.90
210204	Ажилгүйдлийн даатгал	2,652,572.43	2,237,022.77
210205	Эрүүл мэндийн даатгал	28,444,367.40	22,370,230.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	435,388,003.00	465,567,868.00
210301	Гэрэл, цахилгаан	5,242,271.00	5,291,436.50
210302	Түлш, халаалт	429,145,732.00	459,638,431.50
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	638,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,822,040.00	24,291,118.63
210401	Бичиг хэрэг	1,264,400.00	1,725,483.63
210402	Тээвэр, шатахуун	6,499,830.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,310.00	1,055,816.00
210404	Ном, хэвлэл	5,093,300.00	3,817,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,225,100.00	4,356,719.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,725,100.00	9,835,900.00
2105	Нормативт зардал	113,772,792.00	96,466,987.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,537,800.00	5,418,200.00
210502	Хоол, хүнс	63,602,192.00	86,934,887.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42,632,800.00	4,113,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	8,319,400.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	8,319,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	548,000.00

**Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	00.00	548,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,110,000.00	7,512,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,610,000.00	6,504,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,307,025.00	9,160,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,307,025.00	9,160,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,649,867.00	96,797,365.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,239,800.00	62,702,734.51
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,810,800.00	62,702,734.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	858,297.00	159,332.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	858,297.00	159,332.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	121,551,770.00	33,935,299.45
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	121,551,770.00	33,935,299.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>39,262,750.00</u>	<u>21,546,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,262,750.00	21,546,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,262,750.00	21,546,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,262,750.00	21,546,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,262,750.00	21,546,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-39,262,750.00</u>	<u>-21,546,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,001,371,600.00	1,967,276,968.55	-34,094,631.45	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,001,371,600.00	1,967,276,968.55	-34,094,631.45	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,934,626,800.00	1,904,574,234.04	-30,052,565.96	98.4

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,141,806,000.00	1,139,210,643.83	-2,595,356.17	99.7
210101	Үндсэн цалин	829,758,100.00	827,994,275.29	-1,763,824.71	99.7
210102	Нэмэгдэл	239,847,900.00	239,238,203.21	-609,696.79	99.7
210104	Урамшуулал	72,200,000.00	71,978,165.33	-221,834.67	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,143,600.00	151,867,418.91	-2,276,181.09	98.5
210201	Тэтгэврийн даатгал	108,471,600.00	106,786,067.41	-1,685,532.59	98.4
210202	Тэтгэмжийн даатгал	11,418,000.00	11,385,788.91	-32,211.09	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,134,400.00	9,088,308.90	-46,091.10	99.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,283,600.00	2,237,022.77	-46,577.23	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	22,836,000.00	22,370,230.92	-465,769.08	97.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	465,727,200.00	465,567,868.00	-159,332.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	5,900,000.00	5,291,436.50	-608,563.50	89.6
210302	Түлш, халаалт	458,927,200.00	459,638,431.50	711,231.50	100
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	638,000.00	-262,000.00	70.8
2104	Хангамж, бараа материалын зардал	18,965,700.00	18,958,016.00	-7,684.00	99.
210401	Бичиг хэрэг	1,063,500.00	1,063,500.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,500,000.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,063,500.00	1,055,816.00	-7,684.00	99
210404	Ном, хэвлэл	886,200.00	886,200.00	0.00	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,616,600.00	2,616,600.00	0.00	100.
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,835,900.00	9,835,900.00	0.00	100
2105	Нормативт зардал	117,337,400.00	93,370,587.30	-23,966,812.70	79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,321,800.00	2,321,800.00	0.00	100
210502	Хоол, хүнс	110,901,700.00	86,934,887.30	-23,966,812.70	78.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,113,900.00	4,113,900.00	0.00	100.
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,349,400.00	20,349,400.00	0.00	100.
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,800,000.00	9,800,000.00	0.00	100
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	8,549,400.00	8,549,400.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	1,595,200.00	548,000.00	-1,047,200.00	34.3
210702	Дотоод албан томилолт	1,595,200.00	548,000.00	-1,047,200.00	34.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,812,500.00	4,812,500.00	0.00	100

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,804,500.00	3,804,500.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9889800.00	9889800.00	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,889,800.00	9,889,800.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66744800.00	62702734.51	-4,042,065.49	93
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,744,800.00	62,702,734.51	-4,042,065.49	93
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,744,800.00	62,702,734.51	-4,042,065.49	93.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,001,371,600.00	1,967,276,968.55	-34,094,631.45	98.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,527,095,000.00	1,493,159,700.55	-33,935,299.45	97.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,527,095,000.00	1,493,159,700.55	-33,935,299.45	97.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	474,276,600.00	474,117,268.00	-159,332.00	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	474,276,600.00	474,117,268.00	-159,332.00	99.9
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	112.00	112.00	0.00	100.
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	65.00	65.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	46.00	46.00	0.00	100
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,214.00	1,214.00	0.00	100
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,214.00	1,214.00	0.00	100
630001	Төрийн өмчит ЕБС	1,214.00	1,214.00	0.00	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112.00	112.00	0.00	100
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	66.00	66.00	0.00	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	46.00	46.00	0.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,915,702.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,915,702.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,915,702.63
2104	Хангамж, бараа материалын зардал	6,219,302.63
210401	Бичиг хэрэг	661,983.63
210404	Ном, хэвлэл	3,817,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,740,119.00
2105	Нормативт зардал	3,096,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,096,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,915,702.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,915,702.63
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,861,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,237,102.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,817,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ихэрмөрөн- Аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Мядагмаа чанарын хяналт хэрэгжүүлж , аудитор Д.Оюундаваа гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 13 дугаар албан бичгээр “Ихэрмөрөн-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-нд ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Зорилго: “Багш сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан, хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлж, хичээл сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйн хэлбэрүүдийг дэмжин хэрэгжүүлж хоцрогдлыг нөхөх, арилгах үйлд багш нараа бэлтгэн үйл ажиллагаанд нь дэмжлэг болгоно” гэсэн зорилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 237 дугаар тогтоол
- "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал
- Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ны А/35,А/10/9 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим ажиллагсадад олгох ур чадварын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай “ тогтоол
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 дугаар сарын 21-ны А/190 дугаар тушаалаар баталсан сурлагын хоцрогдол арилгах тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны 12 дугаар сарын 03-ноос 11-ны хооронд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар бага эрсдэлтэй гэж үнэлсэн. Шалгалтаар 6 зөвлөмж, 2 актаар хүнсний материалын илүүдэл дутагдалтай холбоотой 1.0 сая төгрөгийн акт тогтоосныг тайлант хугацаанд барагдуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,246.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 44.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 35.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157.7 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	0	0	
Бараа материал	299.5	310.3	10.8
Үндсэн хөрөнгө	7,213.6	7,045.5	(168.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,513.5</b>	<b>7,355.8</b>	<b>(157.7)</b>
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,513.5	7,355.8	(157.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,513.5</b>	<b>7,355.8</b>	<b>(157.7)</b>

Тайлант онд авлага, өглөгийн тооцооны үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 310.3 сая болж 10.8 сая төгрөгөөр өссөн нь үдийн цайг тайлант онд байгууллага өөрөө бэлтгэдэг болсноос хүнсний материалын үнэ 20.5 сая төгрөг, Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны А/41 дүгээр тушаалын дагуу 26.1 сая төгрөгийн ашиглах боломжгүй болсон аж ахуйн болон хангамжийн материал акталж данснаас хассан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансанд Цагаан-уул сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 24.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, БШУЯ-наас 32.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Боловсрол соёлын газраас 4.7 сая төгрөгийн ном тус тус үнэ төлбөргүй авч бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,045.5 сая төгрөг болж 168.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Цагаан-уул сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор 128.0 сая төгрөгийн ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгө акталсан, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 155 нэрийн 96,6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан болон тайлант жилийн 293.2 сая төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,355.8 сая төгрөг болж 157.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 44.2 сая төгрөгөөр буюу 1,9 хувиар өссөн байгаа нь үндсэн хөрөнгийн элэгдэл 54,6 сая төгрөгөөр үдийн цайны зардал 19,5 сая төгрөгөөр өссөн, Цалин нийгмийн даатгалын шимтгэл 17.8 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсөв 2,075.5 сая төгрөгөөр батлагдсан ба 2021 оны 8 р сард 128.7 сая төгрөгийн төсөв нэмж тодотгол хийгдсэн. Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны А/608 захирамжаар сургуулийн сургалтын үйл ажиллагаа Ковид-19 цар тахлын улмаас түр зогссонтой холбоотой тодотгол хийгдэж оны эцэст 2,001.3 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сургууль нь тусгай шилжүүлгийн санхүүжилтээс 1,527.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 474.1 сая төгрөгийн бүгд 2,001.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлогоос 1,967.3 сая төгрөгийг зарцуулж 34.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2

сая төгрөгөөр

№	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Санхүүжилтийн дүн	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	71802 Ерөнхий боловсрол	1974.2	1940,8
2	71806 Насан туршийн боловсрол	27.1	26.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 06-ны А/45 дугаар тушаалаар Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилт 10.6 сая төгрөг, Аймгийн

Аудитын код ХӨА-2022/131/НА-СТА-ТШЗ

Боловсролын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар суралцагчдын мэдлэг чадварын ялгаатай байдлыг оношлох үнэлгээний шалгалтын бичиг хэргийн зардал 0.66 сая төгрөг, Боловсролын газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны А/40 дүгээр тушаалаар ариутгалын зардал 0.97 сая аймгийн орон нутгийн нөөц хөрөнгөнөөс 3.8 сая төгрөг, түрээсийн сурах бичгийн төлбөр 3,8 сая төгрөг бүгд 19.9 сая төгрөг бүгд нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрч зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь 5 сая төгрөгөөс дээш 14 худалдан авалтын 642.9 сая төгрөг, орлогын 2,159.0 сая төгрөг, зарлагын 20 гүйлгээний 333.0 сая төгрөгийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн данс цахим хуудсанд мэдээлвэл зохих холбогдох мэдээллийг 96 хувьтай мэдээлсэн байна. Тендерт шалгараагүй оролцогчийн талаар товч мэдээлэл, шалгараагүй шалтгааныг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар Төсвийн зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх тухай журам”-ыг мөрдөж ажиллах тухай 1 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	401.0	1	401.0	-	-	100.0
Нийт дүн	1	401.0	1	401.0	-	-	100.0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19.9 сая төгрөгийн алдааг залруулж, 3.8 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

2020 онд орон нутгийн хөгжлийн сангаас хүүхдийн дотуур байрны барилгад хийгдсэн 122.66 м2 цонх, 24 м2 хаалга бүгд 19.9 сая төгрөгийг тусад нь вакум цонх, вакум хаалга гэсэн нэрээр барилга дансанд бүртгэсэн байгаа нь урсгал засварын хөрөнгө байгаа тул өмнөх оны үр дүн рүү хааж залруулга хийв.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Хүүхдийн хоолны зардалтай холбоотой асуудал

### 1.1. Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны зардлыг түүвэрлэн шалгахад 2021 онд дотуур байрны хүүхдийн хоолонд 80.9 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсныг нийт хоолны цэсийн 22206 хүүхэд өдөрт харьцуулахад 1 өдрийн дундаж зардал 3646 төгрөг болж нормативаас 171 төгрөг, нийт 3.8 сая төгрөгөөр хэтэрсэн байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

### 1.2. Өгсөн зөвлөмж

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан дотуур байрны хүүхдийн нэг хоногийн хоолны зардлын нормативыг мөрдөж ажиллах

## 2. Бараа материалын тайлантай холбоотой асуудал

### 2.1. Илрүүлэлт:

Хүүхдийн хоол болон үдийн цайны хүнсний материалын складын үлдэгдлийг 2021 оны эцэст салгаж тоолоогүй, хүнсний материалын тайланг гаргахдаа зарим хүнсний материалыг хооронд нь гүйлгэж тооцсон байна.

### 2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4 Үнэн зөв байх гэсэн заалтыг мөрдөж үдийн цайны болон дотуур байрны хүүхдийн хоолны материалын тайланг тус тусад нь хийж тооцоог бодох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		3	23.7	1	19.9	-		-		2	3.8

### БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо 0/23

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо: 2.23

ИХЭРМӨРӨН АУДИТ-ХХК

ХЯНАСАН: АХЛАХ АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Д.ОЮУНДАВАА Огноо

